



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-21-51

2021.10.15 № 9/1868


танай _____-ны № _____-т

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Г.НЭРГҮЙБААТАРТ

Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу Биеийн тамир, спортын газарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийг дүнгийн хамт хургуулэв.

Зөвлөмж, дүнтэй холбогдуулан ажлын төлөвлөгөө гаргаж биелэлтийг ханган тайланг 2021 оны 10 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг мэдэгдье.

Хавсралт...худастай.



Ц.ИДЭРБАТ

231051660

**БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАРТ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

2021 оны 09 сарын 17-ны өдөр

Аймгийн Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Биеийн тамир спортын газарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ДҮГНЭЛТ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал:

1. Өөрийн салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хяналтанд авч хэрэгжилтийг ханган ажиллах байдал хангалтгүй, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг тайлант жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, хэрэгжилтийг тооцоогүй, тайлагнах хяналтад авах тал дээр сул байна.
2. Засгийн газраас 2019 онд 335 дугаартай тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх” үндэсний хөтөлбөрийн 2021 оны хагас жилийн биелэлтийг журмын дагуу тайлагнаагүй, биелэлтийн үнэлгээ тавигдаагүй, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаагүй байна.

Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилт, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт түүний ажлын төлөвлөлттэй уялдсан байдал, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хувьд:

1. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилт хангалтгүй, баяжилт хийгдээгүй, албан тушаалын тодорхойлолт батлагдаагүй.
2. Албан тушаалын тодорхойлолт батлагдаагүй тул түүний ажлын төлөвлөлттэй уялдсан байдлыг хянах боломжгүй байлаа.
3. Байгууллагын үйлчилгээний стандартыг батлуулсан ч түүнийг дагалдан гарсан хяналтын хуудас хэрэглэх журмыг хэрэгжүүлээгүй, харилцаа хандлагын доголдолтой, зарим албан хаагч энгэрийн тэмдэг зүүгээгүй гэх мэт зөрчилтэй.
4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт болох нийгмийн баталгааны хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөө тодорхойгүй, хагас жилийн биелэлт гаргаагүй байна.
5. Тус байгууллагын дарга албан томилолттой, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн ээлжийн амралттай гэсэн шалтгаанаар ажлын байран дээрээ байгаагүй тул бичиг, баримт үзэхэд хүндрэлтэй байсан.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хувьд:

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2021 онд хэрэгжүүлэхээр 5 зорилт 6 арга хэмжээ байгаа ба үүнээс БТСГазар нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 4 арга хэмжээ тусгасан ба 2 арга хэмжээ огт тусгагдаагүй байна.

Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан Журам батлах тухай”, 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг тус тус хангаж ажиллах.
2. Аймгийн Засаг даргын 2021 оны А/340 дүгээр захирамжаар батлагдсан “Хяналтын хуудас хэрэглэх журам”-ын хэрэгжилтийг хангах, тус журам болон байгууллагын үйлчилгээний стандартыг албан хаагч бүрт танилцуулж, баталгааны хуудас гаргаж хувийн хэрэгт хавсаргах.
3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хавсаргах, тайлагнах, ирэх оны төлөвлөгөөг боловсруулахдаа тодорхой, ойлгомжтой байдлаар төлөвлөн хэрэгжүүлэх.
4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд байгууллагын даргыг байлгах.
5. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2 арга хэмжээг тусгах.
6. Засгийн газрын 1996 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” болон Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгож ажиллахыг зөвлөж байна.

ДҮГНЭЛТ БИЧСЭН
АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮН:



Б.ХҮРЭЛЗҮРХ



С.ОЮУН-ЭРДЭНЭ



Н.ЗОРИГТБААТАР

ХЯНАСАН:


АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ



Ц.ГАНЧИМЭГ


ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ц.ЧОГСОМЖАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА



Ж.ГАНБААТАР

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Огноо 2021.09.15

№	Хамрах хүрээ	Дүн/хувиар/
1	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тэдгээрийг хяналтанд авсан байдал	0
2	Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилт	50
3	Байгууллагын дарга болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, жилийн ажлын төлөвлөгөө, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо	50
4	Засгийн газраас хэрэгжүүлж буй Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	50
5	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	-
6	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	50.
7	Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт түүний ажлын төлөвлөлттэй уялдсан байдал	-
8	Төрийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилт	50
9	Салбарын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээ	90
	ДҮН	48,5

Ажиллах хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн

ахлагч ХШУДАХ-ийн даргийн албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

Ц.Ганчимэг

Гишүүд: ХШУДАХ-ийн мэргэжилтэн

Б.Хүрэлзүрх

ТЗУХ-ийн мэргэжилтэн

С.Оюун-Эрдэнэ

НБХ-ийн мэргэжилтэн

Н.Зоригтбаатар